

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Дархан-Уул аймаг дахь салбар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/40/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Дархан-Уул аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:
Утас: 70378845
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 70373089
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Санжаажав
Утас: 70373089
Цахим хаяг: Sanjaajavs@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХААИС-ИЙН ХАРЬЯА ДАРХАН-УУЛ
АЙМАГ ДАХЬ САЛБАР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ П.ГАНХУЯГ ТАНАА

2026.02.14 № 42

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Дархан-Уул аймаг дахь салбар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Хязгаарлалттай” санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй төсвийн хөрөнгөөр баяр ёслол тэмдэглэх, бэлэг дурсгал худалдан авахад 10,877.9 мянган төгрөг, хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлдэх 11,400.0 мянган төгрөг, ажилчидтай холбоотой 72,780.5 мянган төгрөг, 78,032.0 мянган төгрөгийн худалдан авалт хийхдээ тендер сонгон шалгаруулалт явуулаагүй зэрэг нийт 173,090.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, 15.1.6, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 4 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын 1.3-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Хөдөө аж ахуйн их сургуулиас хандиваар ирсэн 100,587.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй машин тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

4526050053

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд гадаад дотоодын 5 төслөөс нийт 2,235,982.4 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан нь өмнөх онд авсан санхүүжилтээс 10.1 хувиар буурсан байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Дархан-Уул аймаг дахь салбар сургуулийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 35 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг ХААИС-ийн ажлын хэсэг 86.0 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,656,146,710.03	697,302,591.39
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		883,416,844.97	183,175,268.78
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		883,416,844.97	183,175,268.78
3121	Төгрөг		534,705,026.20	173,101,952.08
31213	Арилжааны банк дахь харилцах		534,705,026.20	173,101,952.08
3122	Гадаад валют		348,711,818.77	10,073,316.70
31223	Арилжааны банк дахь харилцах		348,711,818.77	10,073,316.70
33	АВЛАГА		338,256,551.07	102,954,654.28
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		50,249,295.66	71,472,027.34
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		16,904,950.00	3,838,000.00
335	Бусад авлага		271,102,305.41	27,644,626.94
33510	Байгууллагаас авах авлага		271,102,305.41	27,644,626.94
34	УРЬДЧИЛГАА		1,208,529,972.13	76,034,286.21
34600	Урьдчилж гарсан зардал		1,208,529,972.13	76,034,286.21
35	БАРАА МАТЕРИАЛ		225,943,341.86	335,138,382.12
351	Түүхий эд материал		4,430,949.20	9,974,519.20
35110	Тусгай зориулалттай материал		4,403,649.20	9,947,219.20
35130	Эм боох материал		27,300.00	27,300.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн		3,603,011.24	968,877.05
354	Хангамжийн материал		217,909,381.42	324,194,985.87
35410	Бичиг хэргийн материал		4,523,473.70	7,208,194.32
35420	Аж ахуйн материал		1,076,726.00	2,966,784.00
35430	Сэлбэг хэрэгсэл		218,000.00	218,000.00
35440	Түлш, шатах тослох материал		2,220,000.00	2,375,000.00
35450	Барилгын засварын материал		11,671,825.71	15,837,017.51
35460	Хүнсний материал		-	41,800.00
35470	Бусад хангамжийн материал		198,199,356.01	295,548,190.04
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		5,965,128,158.17	6,387,245,918.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		5,965,128,158.17	6,387,245,918.79
392	Биет хөрөнгө		4,300,355,708.27	4,717,735,418.89
39201	Барилга, байгууламж, орон сууц		4,644,957,171.79	4,698,680,625.79
39202	Хуримтлагдсан элэгдэл		(946,935,461.22)	(1,101,169,861.06)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		34,510,000.00	34,510,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(28,385,138.83)	(32,253,472.15)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		942,647,987.93	1,166,262,437.13
39206	Хуримтлагдсан элэгдэл		(573,187,286.91)	(351,305,095.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		202,365,299.20	206,981,811.70
39208	Хуримтлагдсан элэгдэл		(127,543,878.06)	(61,898,011.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө		23,800,000.00	25,369,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(8,974,583.46)	(10,321,563.54)
39217	Ном		137,101,597.83	142,878,747.83
393	Биет бус хөрөнгө		1,664,772,449.90	1,669,510,499.90
39301	Програм хангамж		59,178,900.00	55,498,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(45,008,450.10)	(36,590,400.10)
39303	Бусад биет бус хөрөнгө		1,650,602,000.00	1,650,602,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		8,621,274,868.20	7,084,548,510.18
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		818,982,003.05	438,765,685.92
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		818,982,003.05	438,765,685.92
413	Өглөг		25,033,661.39	101,995,679.13
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		19,420,173.32	65,451,827.11
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		4,206,838.09	26,141,600.00
4136	Бусад өглөг		1,406,649.98	10,402,252.02

41361	Байгууллагад төлөх өглөг		-	5,000,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		1,231,532.00	5,402,252.00
41366	Дансны өглөг /ТӨҮГ/		175,117.98	0.02
414	Урьдчилж орсон орлого		793,948,341.66	336,770,006.79
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого		6,900,000.00	8,799,100.00
41440	Бусад урьдчилж орсон орлого		787,048,341.66	327,970,906.79
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		7,802,292,865.15	6,645,782,824.26
51	Засгийн газрын хувь оролцоо		7,802,292,865.15	6,645,782,824.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		2,901,979,135.03	2,901,979,135.03
51101	Өмч: - төрийн		2,901,979,135.03	2,901,979,135.03
512	Хуримтлагдсан үр дүн		393,996,519.29	(568,519,620.90)
51210	Өмнөх үеийн үр дүн		(239,044,241.13)	587,990,419.99
51220	Тайлант үеийн үр дүн		633,040,760.42	(1,156,510,040.89)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		4,506,317,210.83	4,312,323,310.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		<u>8,621,274,868.20</u>	<u>7,084,548,510.18</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		5,277,537,376.19	5,827,406,961.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		3,253,635,913.93	3,138,884,855.17
120	Нийтлэг татварын бус орлого		3,253,635,913.93	3,137,984,855.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		2,609,357,068.93	2,719,693,439.77
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,881,679,647.48	2,354,415,984.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		720,818,848.45	365,277,455.77
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		6,858,573.00	-
120009	Бусад орлого		-	315,634,755.40
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		2,486,345.00	101,022,360.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		641,792,500.00	1,634,300.00
122	Тусламжийн орлого		-	900,000.00
122001	Хандив тусламж /дотоод/		-	900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,023,901,462.26	2,688,522,106.29
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		32,354,415.00	44,659,626.50
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		32,354,415.00	44,659,626.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,991,547,047.26	2,643,862,479.79
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,944,014,171.17	2,643,862,479.79
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		47,532,876.09	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		4,588,724,993.52	6,967,542,102.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,588,724,993.52	6,967,542,102.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,578,702,039.78	6,919,590,537.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,354,993,906.01	1,903,507,595.00
210101	Үндсэн цалин		1,103,424,199.01	1,773,948,333.00
210102	Нэмэгдэл		142,979,707.00	117,469,262.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		108,590,000.00	12,090,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		169,427,407.30	232,820,458.75
210201	Тэтгэврийн даатгал		102,877,566.30	158,023,660.75
210202	Тэтгэмжийн даатгал		17,192,840.00	20,109,748.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		8,828,651.00	10,434,120.00
210204	Ажилгүйдлийн даатгал		8,033,811.00	8,820,743.00
210205	Эрүүл мэндийн даатгал		32,494,539.00	35,432,187.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		130,738,262.01	187,243,357.86
210301	Гэрэл, цахилгаан		38,972,030.61	65,642,291.18
210302	Түлш, халаалт		65,168,908.32	73,983,026.48
210303	Цэвэр, бохир ус		26,597,323.08	47,618,040.20
2104	Хангамж, бараа материалын зардал		48,750,377.03	88,043,727.98
210401	Бичиг хэрэг		4,297,178.86	13,760,249.38
210402	Тээвэр, шатахуун		5,437,385.00	7,340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		9,133,235.74	9,669,475.92

210404	Ном, хэвлэл		376,200.00	347,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,526,000.00	4,569,880.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		7,826,483.00	15,048,374.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		3,340,311.54	6,656,315.35
210408	Бараа материал акталсны зардал		9,918,417.48	5,678,396.97
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/		2,622,975.55	19,613,529.26
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/		4,272,189.86	5,359,707.10
2105	Нормативт зардал		6,348,180.67	4,158,171.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		398,306.67	-
210502	Хоол, хүнс		5,759,874.00	4,009,771.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		190,000.00	148,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		80,033,250.62	94,965,478.49
210601	Багаж, техник, хэрэгсэл		-	4,900,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		674,000.00	2,423,760.00
210604	Урсгал засвар		79,359,250.62	87,641,718.49
2107	Томилолт, зочны зардал		35,090,077.00	41,764,003.00
210701	Гадаад албан томилолт		15,194,890.00	14,832,341.00
210702	Дотоод албан томилолт		18,100,640.00	24,592,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		1,794,547.00	2,339,162.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,782,114,376.69	3,671,831,729.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,699,676,585.60	3,628,224,668.99
210803	Даатгалын үйлчилгээ		-	41,364.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		170,782.00	163,782.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		3,624,134.14	6,501,808.00
210807	Газрын төлбөр		-	497,888.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		922,938.82	1,344,375.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		31,482,063.80	44,000.00
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/		2,755,772.33	157,000.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/		5,060,100.00	5,256,844.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/		38,400,000.00	29,600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		971,206,202.45	695,256,015.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		612,122,069.87	280,173,059.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,898,303.34	13,213,194.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		336,245,150.24	368,135,727.98
210904	Найдваргүй авлагын алдагдал		19,940,679.00	33,734,034.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		10,022,953.74	47,951,565.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		10,022,953.74	47,951,565.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		3,306,153.74	1,016,565.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		1,474,000.00	24,590,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		5,242,800.00	22,345,000.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		<u>688,812,382.67</u>	<u>(1,140,135,141.04)</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		1,712,851.44	8,656,782.01
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		1,712,851.44	8,656,782.01
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		57,484,473.69	25,031,681.86
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		-	78,030.80
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		57,484,473.69	24,953,651.06
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(55,771,622.25)	(16,374,899.85)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		<u>633,040,760.42</u>	<u>(1,156,510,040.89)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>4,636,733,394.44</u>	<u>4,978,973,455.35</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,315,150,566.52	2,699,192,995.64
120	Нийтлэг татварын бус орлого	2,315,150,566.52	2,698,292,995.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,315,150,566.52	2,698,292,995.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,035,163,027.00	2,320,286,984.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	279,987,539.52	378,006,011.64
122	Тусламжийн орлого	-	900,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,321,582,827.92	2,279,780,459.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	32,354,415.00	44,659,626.50
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	32,354,415.00	44,659,626.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,288,941,285.93	2,235,082,379.21
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,287,091,285.93	2,052,661,079.21
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	107,421,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,850,000.00	75,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	287,126.99	38,454.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	287,126.99	38,454.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>4,139,193,216.15</u>	<u>5,399,727,212.49</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,139,193,216.15	5,399,727,212.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,126,779,061.42	5,370,163,501.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,591,746,081.19	1,913,309,652.55
210101	Үндсэн цалин	1,591,746,081.19	1,913,309,652.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	431,559,908.89	289,811,744.23
210201	Тэтгэврийн даатгал	431,559,908.89	289,811,744.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,051,882.52	188,927,252.97
210301	Гэрэл, цахилгаан	30,548,583.35	66,119,893.52
210302	Түлш, халаалт	64,445,372.49	74,706,562.31
210303	Цэвэр, бохир ус	24,057,926.68	48,100,797.14
2104	Хангамж, бараа материалын зардал	118,541,949.62	142,228,573.46
210401	Бичиг хэрэг	56,859,321.00	11,918,914.00
210402	Тээвэр, шатахуун	20,033,038.00	18,574,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,282,919.62	10,807,075.92
210404	Ном, хэвлэл	380,050.00	436,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,350,000.00	3,301,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,636,621.00	97,190,983.54
2105	Нормативт зардал	14,224,885.00	6,145,580.46
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	788,550.00	584,450.00
210502	Хоол, хүнс	11,907,335.00	5,361,130.46

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,529,000.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	154,621,342.00	186,803,940.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,003,670.00	53,189,790.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	108,000.00
210604	Урсгал засвар	104,617,672.00	133,506,150.00
2107	Томилолт, зочны зардал	442,418,838.03	26,296,468.00
210701	Гадаад албан томилолт	320,664,278.48	11,232,164.00
210702	Дотоод албан томилолт	121,754,559.55	14,220,804.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	843,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,188,902,764.17	2,572,942,462.37
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,161,642,175.36	2,549,451,629.94
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	21,400,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	207,782.00
210807	Газрын төлбөр	-	424,650.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	895,238.81	1,314,473.00
210815	Хүүний төлбөрт төлсөн /ТӨҮГ/	-	9,655,595.14
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	4,965,350.00	143,000.00
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	-	11,745,332.29
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,711,410.00	43,697,827.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,249,819.00	22,232,827.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	56,461,591.00	21,465,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,414,154.73	29,563,711.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,414,154.73	29,563,711.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,285,674.74	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	658,979.99	678,957.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	14,692,550.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,469,500.00	14,192,204.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>497,540,178.29</u>	<u>(420,753,757.14)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	56,954,192.00	288,144,601.06
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	56,954,192.00	288,144,601.06
2200	Дотоод эх үүсвэрээр	56,954,192.00	288,144,601.06
225004	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз		24,953,651.06
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	56,954,192.00	263,190,950.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(56,954,192.00)</u>	<u>(288,144,601.06)</u>
14	Бусад эх үүсвэр	-	8,656,782.01
145001	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		8,656,782.01
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	55,771,622.25	-
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	55,771,622.25	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(55,771,622.25)</u>	<u>8,656,782.01</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	384,814,364.04	(700,241,576.19)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	498,602,480.09	883,416,844.97
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	883,416,844.13	183,175,268.78

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,901,979,135.03	4,506,317,210.83	(239,044,241.13)	7,169,252,104.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,901,979,135.03	4,506,317,210.83	(239,044,241.13)	7,169,252,104.73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	633,040,760.42	633,040,760.42
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,901,979,135.03	4,506,317,210.83	393,996,519.29	7,802,292,865.15
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,901,979,135.03	4,506,317,210.83	393,996,519.29	7,802,292,865.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	193,993,900.70	193,993,900.70
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,901,979,135.03	4,506,317,210.83	587,990,419.99	7,996,286,765.85
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(193,993,900.70)	-	(193,993,900.70)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,156,510,040.89)	(1,156,510,040.89)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,901,979,135.03	4,312,323,310.13	(568,519,620.90)	6,645,782,824.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Татаас санхүүжилтийн орлого	172,800,000.00	2,280,680,459.71	2,107,880,459.71	1,319.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	172,800,000.00	44,659,626.50	(128,140,373.50)	25.8
Улсын төсвөөс санхүүжих	172,800,000.00	44,659,626.50	(128,140,373.50)	25.8
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	38,454.00	38,454.00	
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		38,454.00	38,454.00	
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	2,235,982,379.21	2,235,982,379.21	
Хандив тусламж /дотоод/		900,000.00	900,000.00	
Хандив тусламж /гадаад/		2,235,082,379.21	2,235,082,379.21	
Бараа үйлчилгээний орлого	2,899,980,000.00	2,706,949,777.65	(193,030,222.35)	93.3
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,899,980,000.00	2,706,949,777.65	(193,030,222.35)	93.3
Үндсэн үйл ажиллагааны орлого	2,675,980,000.00	2,320,286,984.00	(355,693,016.00)	86.7
Туслах үйл ажиллагааны орлого	224,000,000.00	386,662,793.65	162,662,793.65	172.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,072,780,000.00	4,987,630,237.36	1,914,850,237.36	162.3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,582,780,000.00	5,662,918,162.49	3,080,138,162.49	219.3
УРСГАЛ ЗАРДАЛ	2,582,780,000.00	5,662,918,162.49	3,080,138,162.49	219.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,582,780,000.00	5,662,918,162.49	3,080,138,162.49	219.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,872,980,000.00	1,913,309,652.55	40,329,652.55	102.2
Үндсэн цалин	1,266,608,000.00	1,913,309,652.55	646,701,652.55	151.1
Нэмэгдэл	606,372,000.00	-	(606,372,000.00)	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	289,811,744.23	289,811,744.23	
Тэтгэврийн даатгал		289,811,744.23	289,811,744.23	
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	172,800,000.00	188,927,252.97	16,127,252.97	109.3
Гэрэл, цахилгаан	42,000,000.00	66,119,893.52	24,119,893.52	157.4
Түлш, халаалт	96,000,000.00	74,706,562.31	(21,293,437.69)	77.8
Цэвэр, бохир ус	34,800,000.00	48,100,797.14	13,300,797.14	138.2
Хангамж, бараа материалын зардал	55,500,000.00	147,570,723.46	92,070,723.46	265.9
Бичиг хэрэг	10,500,000.00	11,918,914.00	1,418,914.00	113.5
Тээвэр, шатахуун	11,300,000.00	18,574,600.00	7,274,600.00	164.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,200,000.00	10,807,075.92	607,075.92	106.0
Ном, хэвлэл	500,000.00	5,778,150.00	5,278,150.00	1,155.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	3,301,000.00	801,000.00	132.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,500,000.00	97,190,983.54	76,690,983.54	474.1
Нормативт зардал	18,000,000.00	6,145,580.46	(11,854,419.54)	34.1
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,000,000.00	584,450.00	(1,415,550.00)	29.2
Хоол, хүнс	5,000,000.00	5,361,130.46	361,130.46	107.2
Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,000,000.00	200,000.00	(10,800,000.00)	1.8
Эд хогшил, урсгал засварын зардал	105,600,000.00	428,082,940.00	322,482,940.00	405.4
Багаж, техник, хэрэгсэл		294,468,790.00	294,468,790.00	

Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,600,000.00	108,000.00	(5,492,000.00)	1.9
Урсгал засвар	100,000,000.00	133,506,150.00	33,506,150.00	133.5
Томилолт, зочны зардал	35,000,000.00	26,296,468.00	(8,703,532.00)	75.1
Гадаад албан томилолт	10,000,000.00	11,232,164.00	1,232,164.00	112.3
Дотоод албан томилолт	15,000,000.00	14,220,804.00	(779,196.00)	94.8
Зочин төлөөлөгч хүлээн авах	10,000,000.00	843,500.00	(9,156,500.00)	8.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	242,900,000.00	2,589,512,262.37	2,346,612,262.37	1,066.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	238,539,000.00	2,588,639,002.83	2,350,100,002.83	1,085.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	-	(2,000,000.00)	-
Тээврийн хэрэгслийн татвар		207,782.00	207,782.00	
Тээврийн хэрэгслийн оношлогоо	11,000.00	-	(11,000.00)	-
Газрын төлбөр	1,500,000.00	424,650.00	(1,075,350.00)	28.3
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	850,000.00	240,827.54	(609,172.46)	28.3
Бараа үйлчилгээний бусад зардал	80,000,000.00	43,697,827.45	(36,302,172.55)	54.6
Бараа үйлчилгээний бусад зардал		22,232,827.45	22,232,827.45	
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,000,000.00	21,465,000.00	(58,535,000.00)	26.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,000,000.00	29,563,711.00	(20,436,289.00)	59.1
Бусад урсгал шилжүүлэг	50,000,000.00	29,563,711.00	(20,436,289.00)	59.1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		678,957.00	678,957.00	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,000,000.00	14,692,550.00	(25,307,450.00)	36.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000,000.00	14,192,204.00	4,192,204.00	141.9
Ханшийн тэгшитгэл		(24,953,651.06)	(24,953,651.06)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	883,416,844.97	883,416,844.97	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	183,175,268.78	183,175,268.78	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн 315,634.7 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, одоо ашиглагдаж байгаа тавилга, машин тоног төхөөрөмжийн үнийг 315,634.7 мянган төгрөгөөр үнэлж үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн нь УСНББОУС1, Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”, санхүүгийн тайлангийн “Ангилал” батламж мэдэгдэлтэй тус тус нийцээгүй тул санхүүгийн үр дүнгийн тайлангийн бусад орлого дансанд бүртгэж залруулав.

Мөн аудитаар илэрсэн нийт 173,090.4 мянган төгрөгийн зөрчилд 83,658.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 89,432.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгч ажиллалаа. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

Аудитаар дараах 2 зөрчилд нийт 83,658.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант онд цагаан сар, шинэ жилийн арга хэмжээ тэмдэглэх, бэлэг дурсгалын зүйл худалдан авах зэрэгт нийт 10,877.9 мянган төгрөг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-т “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын 1.3-д “...шинэ жил, байгууллагын болон салбарын ой тэмдэглэхгүй байх” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоов.
2. Ажилчидтай холбоотой үүссэн авлага 72,780.5 төгрөгийн 80.4 хувь нь буюу 58,514.9 төгрөгийн авлага нь сургуулийн захирал П.Ганхуяг, албаны дарга П.Мэнд-Амгалан, ерөнхий нягтлан бодогч Ц.Тунгалаг нартай холбоотой байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар дараах 2 зөрчилд нийт 89,432.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Тайлант онд сургалтын төлбөрийн орлогоос нийт 11,400.0 мянган төгрөгөөр хэрэгцээ шаардлагагүй 300 ширхэг ширээний бүтээлэг худалдан авч, үр ашиггүй зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.4-т “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй тул зөрчлийг арилгах таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

2. Тайлант онд “Новелти” ХХК болон иргэн Д.Занданхүү нараас 78,032.0 мянган төгрөгийн дээжийн сав, сериум худалдан авахдаа тендер сонгон шалгаруулалт явуулалгүй шууд худалдан авсан байна. Энэ нь ТБОНӨБАҮХА тухай хуулийн 44, 45 дугаар зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д “Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;”, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.4-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон байхаар төлөвлөгөөнд тусгах, төсөвт тодотгол орсон бол төсөв батлагдсан даруйд хэрэгжүүлэхээр тусгана” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй тул зөрчлийг арилгах таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

5.3.1. Урсгал зардлын данстай холбоотой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тендер сонгон шалгаруулалтаар худалдан авсан хөрс судлалын лабораторийн тоног төхөөрөмжийг хугацаандаа нийлүүлээгүй "Оюу энд эн" ХХК-д гэрээнд заасан нөхцөлийн дагуу 0.5 хувиар алданги тооцож суутгаагүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Гэрээний биелэлтэд хяналт тавьж, хариуцлагын тогтолцоог сайжруулах, гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжид гэрээнд заасны дагуу алданги тооцож байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн одоо ашиглагдаж байгаа тавилга, машин тоног төхөөрөмжийг 315,634.7 мянган төгрөгөөр үнэлж холбогдох данс бүртгэлд тусгасан боловч Сангийн сайдын 2025 оны А/3 тоот тушаалаар баталсан журамд заасны дагуу бусад орлогоор бүртгэлгүй, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн байна.	1	315,634.7			1	315,634.7	1	315,634.7				
Дүн	1	315,634.7			1	315,634.7	1	315,634.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
Байгууллагын хөрөнгөөр сар шинийн баяр тэмдэглэхэд 1,743.7 мянган төгрөг, шинэ жилийн арга хэмжээ тэмдэглэхэд 6,302.0 мянган төгрөг, бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 2,832.1 мянган төгрөг, нийт 10,877.9 мянган төгрөг зарцуулсан байна.	1	10,877.9	1	10,877.9								
Тайлант онд 11,400.0 мянган төгрөгөөр их хэмжээний ширээний бүтээлэг худалдан авч нөөцөлсөн байна	1	11,400.0			1	11,400.0						
Тайлант онд 102,954.6 мянган төгрөгийн авлагатай гарсан бөгөөд үүнээс 72,792.6	1	72,780.5	1	72,780.5								

мянган төгрөг нь ажиллагчидтай холбоотой авлага байна.												
Тайлант онд 78,032.0 мянган төгрөгийн 2 худалдан авалт хийхдээ ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу зохион байгуулаагүй.	1	78,032.0			1	78,032.0						
Хөрс судлалын лабораторид тоног төхөөрөмж худалдан авах тендер зохион байгуулж, шалгарсан Оюу энд эн ХХК-тай 60,280.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, гэрээний тусгай нөхцөлд гэрээнд заасан хугацаанд тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй бол хоног тутамд 0.5 хувийн алданги тооцохоор тусгасан боловч алданги тооцоогүй санхүүжилтийг бүрэн олгосон байна.	1	-					1	-				
Дүн	5	173,090.4	2	83,658.4	2	89,432.0	1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуульд заасан 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй зарлагын 563,472.1 мянган төгрөгийн 39 гүйлгээ, орлогын 1,949,088.2 мянган төгрөгийн 34, хөрөнгө зарцуулахтай холбоотой 14,838.8 мянган төгрөгийн 4, нийт 2,527,399.2 мянган төгрөгийн 77 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүй байна.	1	2,527,399.2	-	-	1	2,527,399.2		
Дүн	1	2,527,399.2	-	-	1	2,527,399.2		